

Германы Бундестагийн  
тогтоолын үндсэн дээр  
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны  
Хүнс,  
хөдөө аж ахуйн яам



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Герман-Монголын хамтын ажиллагааны  
Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

# Хүнсний аюулгүй байдал, байгаль хамгааллын тухай

Б.Дондов Доктор, дэд профессор УХЭШХ

2019 оны 6 сар



# Хүнсний аюулгүй байдал

- Монгол Улсын Үндсэн хуулийн “хүн амьд явах эрхтэй...” гэсэн суурь зарчим, “Хүний эрхийн түгээмэл тунхаг”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актын хүрээнд бүрдэж байна.


# Хүнсний аюулгүй байдал-Ургамал хамгаалал

- Хүний эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй хүнсний бүтээгдэхүүн аюулгүй эсвэл хүлээн зөвшөөрөгдөх эрсдлийн түвшин юм. Хүнсний аюул нь нүдэнд харагдахгүй бактери, вирус, мөөгөнцөр болон пестицидийн үлдэгдэл зэрэг микробиологи, химийн хордлогоор илэрнэ.
- Ургамлын өвчин –микотоксин –хордлого
- Пестицидийн үлдэгдэл –бүтээгдэхүүн, хөрс

# Пестицидийн импорт, хэрэглээ

- 2013 онд:
  - Инсектицид -22
  - Фунгицид -35
  - Гербицид -29
  - Родентицид -1
  - нийт -86
- 2019 онд:
  - Инсектицид -40
  - Фунгицид -37
  - Гербицид -77
  - Родентицид -5
  - нийт -159

# Байгаль дээрх пестицидийн эргэлт *Pesticide cycle*



# Агаарт пестицид тархах

- Хөдөө аж ахуйн таримал, Үр, Ойд пестицид хэрэглэх
- Салхины элэгдлийн үед хөрсний тоостой
- Хөрсөнд уталт хийхэд – тархана.
- Агаар пестицидээр бохирлогдох нь тухайн пестицидийг хэрэглэх арга, боловсруулалт хийх талбайн хэмжээ, физик-химийн шинж чанар, агаарын температур, салхины хурд-аас хамаарна.
- Агаараас хур тунадас, химийн задралын улмаас чөлөөлөгдөн ус, хөрсөнд унаж хүрээлэн буй орчин дахь эргэлт үргэлжилнэ.

# Усанд пестицид тархах

- Ус – пестицидийн үндсэн дамжуулагч
- Хөрсний болон гүний ус, гол, усан сан, далай тэнгис пестицидийн эцсийн зогсоол болно.
- Зарим пестицид бага концентрацитай ч усны шинж чанарыг өөрчилнө: үнэр, амт
- Архаг болон хурц хордлого, усанд уусдаг хүчилтөрөгчийн агуулгыг бууруулах, химийн шинж чанарыг өөрчлөх, усны шавьжийг устгах
- Ихэнх пестицид усанд амархан задардаг: хөдөө аж ахуйд өргөн хэрэглэж байна.

# Хөрсөнд пестицид тархах


- Хөрсний шавьж, дүгрэг хорхой, мөөгөнцөр, бактерийн өвчин үүсгэгчид, хог ургамлын эсрэг
- Ургамлын газрын дээрхи эрхтнийг шүршихэд хур тунадасаар угаагдах, салхиар зөөвөрлөгдөнө.
- Хөрсний физик, хими, биохими, микробиологийн үйлчлэлийн нөлөөгөөр пестицидийн задралд тэсвэрлэлт-persistence бий болно.
- Хөрсөнд пестицид хадгалагдах нь тэдгээрийн хими, физик шинж чанар, тун, бэлдмэлийн хэлбэр, хөрсний хэв шинж, чийг, температур, физик шинж, хөрсний микрофлор, ургамалжилт, хөрс боловсруулалтын онцлогоос хамаарна.



# Биоценозд пестицидийн нөлөө

- Тоос хүртээгч шавьж, шоргоолж, загас, усны сээр нуруугүйтэн, шувуу устах мөн хүн, амьтанд дам нөлөөлөх
- Энтомофаг шавьж- ашигтай ангуучин, махчин, паразит устах
- Талбайг тогтмол хянаж, прогнозын үндсэн дээр пестицид хэрэглэх

# Хоосон савыг хэрэглэж болохгүй



# Пестицидийн сав баглаа боодлын устгал

- Пестицидийн хоосон савыг гол ус болон талбайд ил задгай хаяхгүй, мөн нийтийн хогонд хийхгүй. Голын усаар зайлж асгаж болохгүй. Савыг сайтар цэвэрлээд дараа нь дахин ашиглагдахгүй болгож хэрчинэ. Өөр зориулалтаар дахин ашиглаж болохгүй.



# Хоосон савыг устгах



- Пестицидийн дилер буюу үйлдвэрлэгчээр дахин боловсруулсан зориулалтын савыг ашиглана
- Хуванцар, металл, шилэн савыг 3 удаа зайлна
- Гялгар уутыг нэг удаа зайлна
- Боломжтой бол усанд уусдаг савлагаа хэрэглэх.
- Пестицидийн хоосон савыг цуглуулдаг газар байдаг бол тийш нь илгээх
- Хоргүйжүүлсний дараа гүн нүх ухаж булах
- Зориулалтын зууханд шатаах
- Пестицидийн 10-60л-ийн хоосон савыг дундуур нь нэг, 100-200л-ийн савыг 4 хувааж хэрэглэх боломжгүй болгож устгалд оруулна. Пестицидийн савыг устгах хамгаалагдсан орчинд гүйцэтгэнэ

**Анхаарал тавьсанд  
баярлалаа!**